



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Төв аймгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70272582
И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com
Факс: 70272582

Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273465
И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Аудитор: Ж.Бямбацогт
Утас: 70273463
И-мэйл: j.beegii@gmail.com

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн Аудитын газрын хаяг:
Төв аймаг Зуунмод сум 6-р баг
Төрийн байгууллагуудын 2-р ордон
Цахим хуудас: tuv@audit.gov.mn

2017 оны 03 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Засаг даргын тамгын газрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-2017/193/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 03 дугаар сарын 25-ныг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн Төв аймгийн Аудитын газрын санхүүгийн аудитын багийн гишүүн аудитор Ж.Бямбацогт хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 25-нд Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Төв аймгийн Аудитын газар аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 26-наас 2017 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 16-нд Төв аймгийн Засаг даргын тамгын газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлд “харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай

мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох, тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг хангаж аж ахуйн талаар үйлчлэх” гэж энэ байгууллагын чиг үүргийг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай Монгол улсын хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38 –д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг гэж заасны дагуу Төв аймгийн Засаг даргын тамгын газрын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг Аймгийн ИТХ баталж аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 1 асуудал эрсдэл өндөр, 3 асуудал эрсдэл дунд, 2 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-В-4 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 36 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 1 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих, шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Төв аймгийн Засаг даргын тамгын газар санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Acolous” програм хангамж ашиглажээ.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл:

Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь 2016 оны 10 сард хийгдсэн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгах нийцлийн аудитаар мэдээлбэл зохих мэдээлэлээс 5 мэдээлэл оруулаагүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 5, нарийвчилсан 1, нийт 6 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагавар Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 84.7 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний 397,974.8 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Төсвөөс гадуур ХААН банкинд 5756001190 тоот данс нээж 3600.0 мянган төгрөгийн түрээсийн орлогыг орон нутгийн төсвийн орлогод оруулахгүй зарцуулж, ажил гүйлгээг тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ”, 23 дугаар зүйлийн 23.9 “Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.9.2 орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого”, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвөөс гадуур дансыг хааж түрээсийн орлогыг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлж байх зөвлөмж өгөв.

2. ИТХ-ын 2015 оны 85 дугаар тогтоолоор татан буугдсан Тээвэр авто замын газрын балансад бүртгэлтэй 42,295.6 мянган төгрөгийн хөрөнгийг Аймгийн ЗДТГ-т шилжүүлснийг бүртгэлд аваагүй нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Үндсэн хөрөнгийг бүртгэлд авах албан шаардлага бичив.

3. Туслах аж ахуйн 32,705.9 мянган төгрөгийн хөрөнгийг ЗДТГ-ын санхүүгийн тайланд нэгтгэж ирүүлээгүй нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулга хийсэн

4. Төрийн байгууллагын ордны талбайг түрээслэхдээ түрээсийн гэрээ байгуулаагүй, түрээсийн үнийг тохироогүй, 1200.0 мянган төгрөгийн түрээсийн орлогыг орон нутгийн төсвийн орлогод тушаалгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9 “Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.9.2 орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Түрээсийн гэрээ байгуулж, орлогыг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлж байх, түүнд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага бичив

5. Цалингийн зардлаас 388.1 мянган төгрөгийн тэтгэмж, НДШ-ийн зардлаас 148.8 мянган төгрөгийн томилолт олгохдоо шууд зардалд бичсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахдаа цалингийн сан болон тэтгэмжийн зардалд зохицуулалт хийхгүй байх зөвлөмж өгөв.

6. Төсвийн хөрөнгөөр албан хаагчдын байрны ипотекийн зээлийн урьдчилгааг төлсөний үлдэгдэл 267,000.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Авлагаар бүртгэж тайлагнах албан шаардлага бичив

7. Кассаар 81,368.7 мянган төгрөгийн гүйлгээ хийхэдээ харилцагч байгууллагын бэлэн мөнгөний орлогын баримтгүй 46,526.6 мянган төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэлд бүртгэсэн, зөвшөөрөгдсөн хэмжээг хэтрүүлж 12 удаагийн гүйлгээгээр 37,462.4 мянган төгрөгийг кассст авсан нь НББ-ийн тухай хуулийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлэхээр шийдвэрлэв

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

8. Баяндэлгэр суманд ажилласан албан хаагчдад томилолт олгохдоо 2,940.0 мянган төгрөгийн хоолны зардлыг давхардуулан олгосон нь ЗГ-ын 1995 оны 218 дугаар тогтоолын “Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох журам”-ын 6. Албан томилолтын зардалд дор дурдсан зардлууд орно: а/ уналгын зардал, б/ байрны зардал, в/ зам хоногийн зардал гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан томилолт олгохдоо давхардуулан олгохгүй байх зөвлөмж өгөв

9. Барилга байгууламж дансанд 154.6 мянган төгрөгийн модны суулгац бүртгэсэн нь УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө” 13. Тодорхойлолт Үндсэн хөрөнгө гэдэг нь бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үйлдвэрлэлт буюу нийлүүлтэд, бусдад түрээслэхээр эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж буй байгууллагын эзэмшиж байгаа хөрөнгө байна гэснийг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Барилга, байгууламж данснаас модны суулгацыг хасах албан шаардлага бичив

10. 21,140.6 мянган төгрөгийн шатахууныг орлогод авалгүй шууд зардалд бичсэн, спидометрийн заалтгүй замын хуудсаар 4,109.8 мянган төгрөгийн шатахууны тооцоо хийсэн нь НББ-ийн тухай хуулийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Шатахууныг бараа материалын дансанд бүртгэж, жолоочийн тооцооны хуудсанд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв

11. Засаг даргын нөөц сангаас гарсан 312,588.7 мянган төгрөгийг тооцооны данс болон бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардал дансанд бичилт хийсэн нь НББ-ийн тухай хуулийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: шууд зардалд бичилгүй холбогдох дансанд бичилт хийж байх зөвлөмж өгөв

12. 3978.5 мянган төгрөгийн томилолтын урьдчилгаа болон томилолт, 15672.7 мянган төгрөгийн тэтгэмж, лист, цалинг олгохдоо тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардал дансанд бичилт хийсэн нь НББ-ийн тухай хуулийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: өглөг, авлагын дансанд бүртгэж байх зөвлөмж өгөв

13. Веб удирдах системийн жилийн лицензийн эрхийг сунгахдаа 853.4 мянган төгрөгийн бэлэн мөнгөөр тооцоо хийсэн боловч "Үндэсний Дата төв"-ийн бэлэн мөнгөний орлогын баримтгүй гүйлгээ хийсэн нь НББ-ийн тухай хуулийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Бэлэн мөнгөөр тооцоо хийсэн тохиолдолд харилцагч байгууллагын бэлэн мөнгөний орлогын баримтыг хавсаргаж байх зөвлөмж өгөв

Материаллаг бүс залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад материаллаг 32,705.9 мянган төгрөгийн алдааг залруулсан болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох бараа материал, үндсэн хөрөнгийг авч үзнэ

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 792,767.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 397,892.7 мянган төгрөгийн зөвлөмж, 698.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 315,642.5 мянган төгрөгийн албан шаардлага өгөгдлөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд аудит хийж 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн хариуг албан бичгээр Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Хязгаарлалтай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Төв аймгийн Засаг даргын тамгын газрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 9 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ж.БЯМБАЦОГТ